Монгол Улсын Их Сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхим

*uyanga@seas.num.edu.mn

Хүлээн авсан: 2018.04.02, засварласан: 2018.09.06, зөвшөөрсөн: 2018.09.20

Хураангуй

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу албан татвар төлөгч нь тухайн татварын жилд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэл хувийг буцаан олгох, сугалааны тохирлоор гэсэн 2 төрлийн урамшууллыг олгож эхэлсэн. Тус хууль хэрэгжиж эхэлсэн эхний жилийн үр дүнд 2017 онд нийт 497,465 иргэнд 31.5 тэрбум төгрөг, 2018 онд 654,168 иргэнд 78.1 тэрбум төгрөгийн буцаан олголтыг олгоод байна. Иргэдийн хувьд төлбөрийн баримтаа бүртгүүлэх идэвхтэй бүртгүүлж байгаа хэдий ч нийт хэвлэгдсэн баримтын 40 орчим хувь нь бүртгэгдэхгүй орхигдож байна. Энэ нь томоохон зах, худалдааны төв, сум суурин газарт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчид хуулийг бүрэн хэрэгжүүлэхгүй, төлбөрийн баримт олгохгүй, технологийн асуудал бүрэн шийдэгдээгүй байгаатай холбоотой. Иймээс татвар төлөгч болоод хэрэглэгч талдаа ямар нэгэн хүндрэл учруулахгүйгээр цахим баримтыг олгох, бүртгэх шийдэл шаардлагатай байна. Энэхүү өгүүлэлд бид Нэмүү өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС)-д эцсийн хэрэглэгчийн цахим баримтыг автоматаар бүртгэх хялбар шийдлийг авч үзлээ.

Түлхүүр үг: Татварын систем, татвар төлөгч, НӨАТУС, төлбөрийн баримт, ebarimt, бэлэн бус төлбөр


1. Нэмүү өртгийн албан татварын урамшууллын систем

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нь хувь хүн, хуулийн этгээдийн Монгол Улсад импортоор оруулсан, эсхүл Монгол Улсаас экспортод гаргасан болон Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулах зорилготой. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсний төлбөрийн баримтын мэдээллийг цуглуулах, боловсруулах, тайлагнах нэгдсэн систем болох Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем (НӨАТУС)-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.

Энэхүү системийг нэвтрүүлснээр НӨАТ төлөгч эцсийн хэрэглэгчийг урамшуулах замаар татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн татвараас зайлсхийх оролдлого, нуун дарагдуулах, хуурамч баримт үйлдэх зэрэг олон сөрөг үйлдлийг илрүүлэх, улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх, татварын суурь баазын бэхжүүлэх зэрэг олон давуу талыг

бий болгосон. Улсын төсөв 2016 онд 570 гаруй тэрбум, 2017 онд 1.3 орчим их наяд төгрөгөөр давж биелсэн нь уг хуулийн хэрэгжилттэй шууд холбоотой гэж үзэж болохоор байна. Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв улсын үйлдвэрийн газар (ГТСМТТ УҮГ)-аас гаргасан мэдээгээр НӨАТУС-д бүртгэгдэх шаардлагатай нийт татвар суутган төлөгчдийн (хувь хүн хуулийн этгээд) 50 гаруй хувь нь бүртгэгдээд байна. 2018 оны байдлаар уг системд 1.2 сая гаруй эцсийн хэрэглэгч бүртгэгдсэнээс 650-800 мянга нь идэвхтэй хэрэглэгч аж. Эдгээр хэрэглэгч нь жилд дунджаар 250 баримт бүртгүүлж, 120000 төгрөгийн буцаан олголтыг авдаг. 2017 оны байдлаар сард дунджаар 20000 гаруй баримт хэвлэгдэж, хэвлэгдсэн баримтын тоо нэмэгдэж байна [7]. Зураг 1. Гэвч эцсийн хэрэглэгч буюу татвар төлөгчийн баталгаажуулсан баримт 60 орчим хувьтай байна.

Хэвлэгдсэн болон системд баталгаажсан төлбөрийн баримтын үзүүлэлтээс харахад системийн хэрэглээ улам өсөн нэмэгдэж, бүртгэгдсэн баримтын тоо сар тутам тогтмол



Зураг 1. 2017/01-2018/03 сарын хооронд хэвлэгдсэн, баталгаажсан баримтын тоо, сараар

өсөж байгаа ч баталгаажгаагүй баримт харьцангуй өндөр хувийг эзэлж байна. Бидний үзэж буйгаар дараах нөхцөл байдал, шалтгааны улмаас системд холбогдох шаардлагатай татвар төлөгчдийг бүрэн хамруулж чадахгүй байна. Үүнд:

- Томоохон зах, худалдааны төв, сум суурин газарт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчид төлбөрийн баримт олгодоггүй.
- ААН-үүд төлбөрийн баримтаа олгосон НӨАТУС-д гүйлгээний мэдээллээ илгээдэггүй.
- Төлбөрийн баримтын хэвлэлтийн чанар шаардлага хангаагүйгээс баримтын дугаар, кодыг таних боломжгүй, улмаар хэрэглэгч системд мэдээллийг алдаатай оруулдаг.
- Төлбөрийн баримт олгох технологийн асуудал, нөхцөл бүрэн шийдэгдээгүй.
- Томоохон зах, худалдааны төв, сум суурин газарт үйл ажиллагаа эрхлэгч тухай бүр баримт хэвлэх, олгох боломжгүй.
- Хэдийгээр ухаалаг утастай хэрэглэгчийн тоо нэмэгдэж байгаа боловч ухаалаг утасны боломжийг бүрэн ашигладаггүй.
- Ухаалаг утас ашигладаг хэрэглэгчийн тооноос 2 дахин бага хэрэглэгч интернэт ашигладаг.
- Ихэнх хэрэглэгч татварын ашиг тус, давуу талыг ойлгодоггүй, дарамт шахалт гэж үздэгээс татвараас зайлсхийх, орлогоо нуун дарагдуулах хандлага их.

Иймээс татвар төлөгч болоод хэрэглэгч талдаа ямар нэгэн хүндрэл учруулахгүйгээр НӨАТУС-д

холбох, цахим баримтыг олгох, бүртгэх хялбар, хүртээмжтэй шийдэл шаардлагатай байна.

2. Төлбөрийн баримтын бүртгэлийн үйл ажиллагаа

Төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг “төлбөрийн баримт” гэдэг [1]. Албан татвар суутган төлөгчийн борлуулалтыг төлбөрийн баримтад заагдсаны дагуу бүртгэж, бүртгэлийн мэдээллийг төлбөр тооцооны бүртгэлийн системд дамжуулах тусгай зориулалт бүхий кассын машин, түүний салшгүй хэсэг болсон ПОС терминал буюу түүнтэй адилтгах программ хангамж бүхий тоног төхөөрөмж буюу бүртгэлийн машин [3] ашиглана. Албан татвар суутган төлөгч бүр НӨАТУС-д бүртгүүлж, хэрэглэгчийн төлбөр хийсэн тухай бүр төлбөр тооцооны мэдээллийг системд бүртгэх, бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгох, хэрэглэгчийн системд бүртгэгдсэн төлбөрийн баримтын мэдээллийг 3 хоногийн дотор багтаан борлуулалтын нэгдсэн системд илгээх үүрэгтэй.


Төлбөрийн баримт нь дараах мэдээллийг агуулна [3]. Үүнд:

- Албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгч ба хувь хүний таних тэмдэг, нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар
- Дахин давтагдашгүй төлбөрийн дугаар
- Төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох огноо
- Бүртгэлийн машины дугаар
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний нэр
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний код
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний тоо хэмжээ
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний үнэ
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний НӨАТ шингэсэн нэгж дүн
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний НӨАТ шингэсэн нийт дүн
- Худалдаа хийгдсэн бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцооны дүн
- Нийт худалдаж авсан бараа, ажил үйлчилгээний НӨАТ шингэсэн нийт дүн
- Нийт худалдан авсан бараанд төлсөн НӨАТ-ийн дүн
- Төлбөр төлсөн дүн (бэлэн ба бэлэн бусаар харуулах)
- Төлбөрийн хариулт (бэлэн гүйлгээ)
- Сугалааны дугаар
- Буцаалтын бар код
- Нууцлалын QR код

НӨАТУС-д төлбөрийн баримт бүртгэх үйл ажиллагаа дараах байдлаар хийгддэг. Зураг 2. Үүнд:

1. Албан татвар суутган төлөгч эцсийн хэрэглэгчид төлбөрийн цаасан баримтыг олгоно.
2. Албан татвар суутган төлөгч системд гүйлгээний мэдээллийг илгээнэ.
3. Эцсийн хэрэглэгч боломжит (вэб сайт, гар утасны программ, 131313 утас) сувгаас сонгон төлбөрийн баримтаа системд бүртгэнэ. Төлбөрийн баримт нь албан татвар суутган төлөгч системд гүйлгээний мэдээллийг илгээх хүртэл “хүлээгдэж буй” төлөвт хадгалагдана.
4. Хэрэв албан татвар суутган төлөгч системд гүйлгээний мэдээллийг илгээсэн бол тухайн төлбөрийн баримт “хүлээгдэж буй” төлөвөөс “баталгаажсан” төлөвт шилжинэ.
5. Эцсийн хэрэглэгчид төлбөрийн баримтын төлөвийг системээс ангилан харуулна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд зориулсан бараа, агуулах, борлуулалтын бүртгэл, төлбөр тооцооны бүрэлдэхүүн хэсэг, бараа, ажил, үйлчилгээний нэгдсэн системтэй холбогдон ажиллах баталгаажсан тоног төхөөрөмж болон системийг хэрэглэгчийн систем [1] гэдэг. Дээр дурдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ААН, байгууллага нь хэрэглэгчийн системтэй байх шаардлагатай. Өдгөө НӨАТУС-д холбогдон эцсийн хэрэглэгчид төлбөрийн баримтыг олгож буй дийлэнх байгууллага, ААН нь хэрэглэгчийн системтэй буюу үйл ажиллагаа явуулж буй ажлын байрны хувьд тогтвортой, сүлжээний дэд бүтцээ шийдэж чадсан, кассын машин байршуулах зай талбайтай. Харин Нарантуул, Хархорин, Хүчит шонхор, Тэди, Зуун айлын барилгын материалын дэлгүүрүүд зэрэг томоохон зах, худалдааны төвүүдэд лангуу түрээслэн ажиллуулдаг татвар төлөгчид өнөөг хүртэл НӨАТУС-д холбогдох боломжгүй, кассын машин суурилуулах зай талбайгүй, сүлжээ ороогүй, кассын программгүй. Эдгээр шалтгааны улмаас үйлчлүүлэгчдэд төлбөрийн баримтыг олгохгүй, эцсийн хэрэглэгчийг хохироодог.



Зураг 2. Төлбөрийн баримтын бүртгэлийн үйл ажиллагаа

Иймээс одоогийн үйл ажиллагааг өргөжүүлэх замаар системийн хэрэглээг өргөжүүлэх, эцсийн хэрэглэгчийн бүртгүүлсэн, баталгаажуулсан баримтын үзүүлэлтийг дээшлүүлэх, татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн татвараас зайлсхийх оролдлого, нуун дарагдуулах, хуурамч баримт үйлдэх зэрэг сөрөг үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, улмаар улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжтой.

3. Санал болгож буй шийдэл


Төлбөрийн баримтын баталгаажилтыг нэмэгдүүлэх нэг арга бол хэрэглэгчийн худалдан авалт бүрийн баримтыг тухай бүр системд бүртгэх явдал юм. Үүний тулд хэрэглэгчийг тухайн байгууллага, иргэнээр үйлчлүүлэх үед нь түүнийг таньж чадах нь чухал. Хэрэглэгчийг танихад иргэний бүртгэл, үүрэн холбооны хэрэглэгчийн бүртгэл, арилжааны банкны дансны мэдээллийг ашиглах боломжтой. Эдгээрээс улсын хэмжээнд хамгийн том дэд бүтцийг бий болгосон салбар бол банкны салбар. Иймд арилжааны банкны төлбөрийн картны мэдээллийг НӨАТУС-ийн хэрэглэгчийн код ба цахим шуудангийн хаягтай уялдуулснаар тухайн хэрэглэгчийг бэлэн бусаар төлбөр тооцоо хийсэн тухай бүр таньж НӨАТУС-д автоматаар бүртгэх боломжтой хэмээн үзэж байна. Төлбөрийн карт ашиглах шийдлийг дараах үндэслэлээр сонгосон болно. Үүнд:

- Төлбөрийн картны хэрэглээ өндөр: Монгол банкны 2017 оны 3 дугаар сарын Төлбөрийн системийн тайланд дурдсанаар тайлант хугацааны байдлаар арилжааны банканд ашиглаж буй нийт 3,886,196 карт байгаагаас 1,650,128 нь идэвхтэй ашиглагдаж байна. Үүнээс 2,713,197 нь төгрөгийн карт [5].
- Төхөөрөмжийн тоо хангалттай: 2017 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 32,315 карт уншигч төхөөрөмж байгаагаас 24,868 нь ПОС терминал, 3,403 нь МПОС терминал, 2,019 нь ПОБ терминал, 2,025 нь АТМ төхөөрөмж байна [5].
- Интернэт ба мобайл хандалтын эрхтэй хэрэглэгчдийн тоо өссөн: Монгол банкны 2017 оны 3 дугаар сарын Хөдөлгөөнт

банкны тайланд дурдсанаар тайлант хугацааны байдлаар интернэт хандалтын эрхтэй хэрэглэгчийн тоо 3,087,452, үүнээс 1,378,428 нь орон нутгийн хэрэглэгч, үлдэх 1,709,024 нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон хотын хэрэглэгч. Мобайл хандалтын эрхтэй хэрэглэгчийн тоо 3,087,962, үүнээс 216,989 нь орон нутгийн хэрэглэгч, үлдэх 1,039,973 нь Улаанбаатар, Дархан-Уул, Орхон хотын хэрэглэгч [4].

- Интернэт ба мобайл хандалтаар хийх гүйлгээний тоо өссөн: 2017 оны 3 дугаар сарын байдлаар интернэт хандалтаар банк хооронд 1,117 тэрбум төгрөгийн 2,485,496 гүйлгээ, банкны данс хооронд 4,092 тэрбум төгрөгийн 5,436,163 төлбөр тооцооны гүйлгээний хийгджээ. Харин мобайл хандалтаар банк хооронд 183,1 тэрбум төгрөгийн 973,117 гүйлгээ, банкны данс хооронд 26 тэрбум төгрөгийн 204,320 төлбөр тооцооны гүйлгээний хийгджээ [4].
- Арилжааны банкуудын ПОС терминал байршуулсан мерчантын тоо 13,000.

Судалгааны ажлын хүрээнд бид түүврийн аргаар Улаанбаатар хотын 300 гаруй хэрэглэгчээс худалдан авалтын төлбөр тооцоо, НӨАТУС-ийн хэрэглээний талаар асуулга явуулав. Санал асуулгаар (Зураг 3) судалгаанд хамрагдагсдын 96.4 хувь нь НӨАТУС-ийг идэвхтэй хэрэглэдэг, 58.3 хувь нь төлбөрөө бэлнээр, 41.7 хувь нь банкны картаар хийдэг гэсэн хариултыг тус тус өгчээ. Харин худалдан авалтаа өөрийн эзэмшдэг банкны картаар хийсэн тохиолдолд төлбөрийн баримтаа гараар бүртгэхгүйгээр мэдээллийг цахим баримтын бүртгэлд шууд автоматаар



Зураг 3. Санал болгож буй төлбөрийн баримтыг автоматаар бүртгэх шийдэл

бүртгэх шийдлийг нийт оролцогчдын 83.3 хувь нь дэмжиж, үлдэх 16.7 хувь нь “дэмжихгүй”, Хэрэглэгч худалдан авалтын төлбөрийн баримтаа автоматаар НӨАТУС-д бүртгүүлж цахим төлбөрийн баримтыг авахыг зөвшөөрсөн тохиолдолд дараах үйлдлүүд хийгдэнэ. Үүнд:

1. Хэрэглэгч НӨАТУС-д бүртгэлтэй гар утасны дугаараа арилжааны банкны ПОС терминал төхөөрөмжид оруулна.
2. Банкны ПОС терминал онлайн горимд ажиллах тул хэрэглэгчийн оруулсан утасны дугаар, QR мэдээллийг банкны системд хүсэлт хэлбэрээр илгээнэ.
3. Банкны систем нь хэрэглэгчийн утасны дугаараар НӨАТУС-тэй холбогдсон лавлах зориулалт бүхий сервисийг дуудна.
4. Лавлах зориулалт бүхий сервис нь НӨАТУС-ээс хэрэглэгчийн дугаар (ID), цахим шуудангийн хаягийг хайна.
5. Хэрэглэгчийн дугаар, цахим шуудангийн хаягийг хайлтын илэрцийг лавлах сервис илгээнэ.
6. Лавлах сервисээс банкны системд хэрэглэгчийн дугаар, цахим шуудангийн хаягийг илгээнэ.
7. Банкны системээс хэрэглэгчийн дугаар, харгалзах QR мэдээллийг НӨАТУС-ийн бүртгэх сервис илгээж бүртгүүлнэ.
8. Банкны системд хэрэглэгчийн картын дугаарын мэдээлэлд НӨАТУС-ийн хэрэглэгчийн дугаарыг нэмж хадгална.

Ингэснээр дараагийн удаа тухайн хэрэглэгчийн дугаарыг НӨАТУС-ээс дахин лавлах шаардлагагүй болж дээрх 3-6 дугаар үйлдлийг алгасах боломжтой болно.


9. Хэрэглэгчийн цахим шуудангийн хаягийг тухайн ААН-д илгээнэ.
10. ААН-ийн кассын системээс төлбөрийн баримтыг хэрэглэгчид цахим шуудангаар илгээнэ.
11. ААН борлуулалтын мэдээллээ НӨАТУС-д 72 цагийн дотор илгээнэ

Дээр дурдсан үйл ажиллагааны 1-6 дугаар үйлдлүүд нь тухайн төлбөрийн картын хувьд нэг удаа хийгдэнэ. Арилжааны банкны системд төлбөрийн картыг НӨАТУС-ийн хэрэглэгчийн бүртгэлтэй холбосон мэдээллийн сан үүснэ. Ингэснээр гар утасны дугаар нь бүртгэгдсэн хэрэглэгчийн дараагийн худалдан авалтад гар утасны дугаарыг дахин оруулж, НӨАТУС-ээс хэрэглэгчийг лавлах шаардлагагүй болно. Тухайн хэрэглэгчийг банкны системээс хэрэглэгчийн ID дугаараар хайж олоод 7-12 дугаар үйлдлийг гүйцэтгэх юм.

Шийдлийг дараах байдлаар хэрэгжүүлнэ.

Үүнд:

- 1.0 Картаар худалдан авалт хийх бүрд үйлчлүүлэгчээс төлбөрийн баримтыг шууд бүртгүүлэх эсэхийг лавлана.
- 1.1, 1.1.1 Төлбөрийн баримтыг шууд бүртгэхгүй гэвэл цаасан баримтыг заавал хэвлэж өгнө.



Зураг 4. Санал болгож буй шийдлийг хэрэгжүүлэх зураглал

- 1.2 Хэрэв шууд бүртгүүлнэ гэвэл хэрэглэгчийн картыг хэрэглэгчийн дугаартай холбогдсон эсэхийг банкнаас шалгана.
- 1.2.1, 1.2.4, 1.2.4.1 Хэрэглэгчийн бүртгэл хийгдсэн тохиолдолд сугалаа бүртгэх сервисийг дуудаж, амжилттай холбогдсоны дараа баримтыг цахим шуудангаар илгээнэ. Цахим шуудан амжилттай илгээгдвэл цаасан баримт хэвлэх шаардлагагүй.
- 1.2.4.2, 1.2.4.1.2 Сугалаа бүртгэх сервис амжилтгүй, эсвэл цахим шуудан илгээгдээгүй тохиолдолд цаасан баримтыг заавал хэвлэж өгнө.
- 1.2.2, 1.2.3, 1.2.3.1 Хэрэглэгчийн бүртгэл бүрэн бус бол хэрэглэгчийн дугаар болон цахим шуудангийн хаягийг тухайн хэрэглэгчийн банкны картын дугаартай амжилттай холбосны дараа хэрэглэгчийн баримтыг шууд бүртгэнэ.
- 1.2.3.2 Хэрэглэгчийн дугаар болон цахим шуудангийн хаягийг тухайн хэрэглэгчийн банкны картын дугаартай холбож чадаагүй тохиолдолд цаасан баримтаа заавал хэвлэж өгнө.

Шийдлийг хэрэгжүүлэхийн тулд арилжааны банк, оператор байгууллагын тухайд:

- Хэрэглэгчийн дугаар, цахим шуудангийн хаягийг банкны карттай холбоно.
- Банкны ПОС терминал, хэрэглэгчийн систем хоорондоо хэрэглэгчийн худалдан авалтын мэдээлэл солилцоно.

Кассын системийн тухайд:

- Хэрэглэгч баримтаа цахимаар бүртгэх сонголттой байна.
- Цахимаар бүртгэхгүй, эсвэл интернэт холболтгүй үед цаасан баримт хэвлэх боломжтой байна.
- Хэрэглэгч бэлнээр төлбөр тооцоо гүйцэтгэж байгаа тохиолдолд худалдан авалт бүрд утасны дугаараар хэрэглэгчийг хайж, төлбөрийн баримтыг автоматаар бүртгэнэ.
- Сугалаа бүртгэх сервис ашиглаж байгаа тохиолдолд интернэт холболттой байж, баримтын мэдээллийг цахим шуудангаар заавал илгээнэ.

4. Дүгнэлт

Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан татварын албаны удирдах дээд байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг хуулийн этгээд, хувь хүн дагаж мөрдөх үүрэгтэй [6]. Нэмэгдсэн өртгийн

албан татварыг ногдуулах, төсөвт төвлөрүүлэх, буцаан олгох, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулах [1] НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад НӨАТУС дорвитой хувь нэмэр оруулж, чухал үүргийг гүйцэтгэж байна. Бидний санал болгож буй шийдлийг улсын хэмжээнд бэлэн бус төлбөр тооцооны төлбөрийн баримтыг автоматаар бүртгэхэд ашиглах бүрэн боломжтой. Ялангуяа томоохон зах, худалдааны төв, сум суурин газарт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчид нэвтрүүлэхэд татвар төлөгч болоод хэрэглэгч талдаа ямар хүндрэл учруулахгүйгээр цахим баримтыг олгох, бүртгэх асуудлыг хялбараар шийдэх юм.

Хүснэгт 2. Хялбар бүртгэлийн сервисийн хамрах хүрээ

№	Байгууллагын нэр	Хэрэглэгчийн тоо	Бүртгэгдсэн баримтын тоо	Орчин
1	Хаан банк	6630	24443	Үндсэн
2	Голомт банк	146	1609	Үндсэн
3	Мобиком ХХК	35769	162355	Үндсэн
4	Юнител ХХК (Юнивишн)	70	103	Тестийн
5	Скайтел ХХК	94	102	Тестийн
6	Худалдаа хөгжлийн банк	1030	1320	Үндсэн

Хялбар бүртгэлийн шийдлийг 2018 оны 5 дугаар сараас эхлэн хэрэглээнд туршин нэвтрүүлсэн. Эхний ээлжинд Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Мобиком ХХК үндсэн орчинд, арилжааны 6 банк, үүрэн телефоны оператор байгууллага, банк бус санхүүгийн байгууллагууд туршилтын орчинд хэрэгжүүлж байна.

БАРИМТЫН ЖАГСААЛТ

6

Сугалаа	Бүртгэгдсэн огноо	Төлөв
WN70549889	2018-06-20 00:33:27	Хүлээгдэж буй
OT43486373	2018-06-17 21:56:29	Бүртгэгдсэн
IM21537569	2018-06-17 10:29:15	Бүртгэгдсэн
GE64874122	2018-06-16 13:11:22	Бүртгэгдсэн
XX26487043	2018-06-16 12:41:42	Бүртгэгдсэн
KR52312132	2018-06-16 12:41:11	Бүртгэгдсэн
XT27016873	2018-06-16 12:41:03	Бүртгэгдсэн
ZF39397536	2018-06-16 12:40:48	Бүртгэгдсэн
HO96726700	2018-06-13 21:28:33	Бүртгэгдсэн

Зураг 5. Төлбөрийн баримт бүртгэгдсэн байдал

Шийдлийн хэрэгжүүлэлтийн хүрээнд хэрэглэгчид утасны дугаараар бүртгэлтэй цахим шуудангаар илгээгдсэн WH70549889 сугалааны код бүхий төлбөрийн баримтыг Зураг 5-д, НӨАТУС-д тухайн баримт бүртгэгдсэн байдлыг Зураг 6-д тус тус харуулав.

Subject: Төлбөрийн баримт

From: vat-mailer@mobiocom.mn

To: tvshnm@yahoo.com

Date: Tuesday, June 19, 2018, 11:09:05 PM GMT+8

ЭРХЭМ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ.

Төлбөр төлсөн баримтыг илгээж байна.

МОВИКОМ КОРПОРАЦИ
МОНГОЛ УЛС
НӨАТ Т/Д 2072572

Утасны дугаар 99008909
Худалдан авалт хийсэн огноо 2018-06-19 23:08:47
Сугалааны код WH 70549889
ДДТД 000002072572020180619000001083327

№	Барааны төрөл	Барааны код	Үндсэн үнэ	НӨАТ	Нийт
1	Худалдан авалт - 99008909	8413	1363.64	136.36	1500.00



Зураг 6. Цахим шуудангаар илгээгдсэн төлбөрийн баримт

Бэлэн бусаар хийгдсэн төлбөрийн баримтын бүртгэлийн үйл ажиллагааг автоматжуулснаар цаасан баримт олгох шаардлагагүй, цаас болон хэвлэлтийн зардал хэмнэх эдийн засгийн үр ашгаас гадна эцсийн хэрэглэгчийн болоод татварын албаны үйл ажиллагааг хялбар, шуурхай болгох давуу талтай. Тухайлбал:

- Төлбөрийн баримт хэвлэх цаасны зардал багасна.
- Цаас ашиглалтыг багасгах нь байгаль орчинд эерэгээр нөлөөлнө.
- Хэрэглэгчийн гаргадаг механик алдаа багасна.
- Баталгаажсан баримтын тоо эрс өснө.
- Хуулийн хэрэгжилт сайжирч, татварын орлого нэмэгдэнэ.
- Өдгөө ашиглаж байгаа бүртгэлийн сувгуудад QR код уншигдахгүй байх, баримт дээрх мэдээлэл стандартын шаардлага хангахгүй, бүдэг байх зэрэг төлбөрийн баримт бүртгүүлэхэд тулгардаг хүндрэлийг бүрэн шийднэ.

- Иргэдийн интернэт, цахим шуудан, ухаалаг утасны хэрэглээ өргөжинө.

Төлбөрийн баримтын хялбар бүртгэл шийдлийг нэвтрүүлснээр бүртгэлийн үйл ажиллагааг хялбар болгох төдийгүй, эдийн засгийн хувьд ихээхэн ашигтай. 2016-2017 оны төлбөрийн баримтын статистик мэдээлэлд үндэслэн хийсэн хялбар тооцооллыг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Цаасны зарцуулалтын тооцоолол

Он	Хугацаа	Төлбөрийн баримтын тоо [7]	Харьцуулж тооцсон модны тоо*
2017	Жилд	365,768,830	5,978
2017	өдөрт	654,163	18
2016	Жилд	203,136,352	4,875
2016	өдөрт	556,537	14

* 12.2 өндөр, 15-21 см хөндлөн огтлолтой мод

НӨАТУС-ийн хэрэглэгчийн код ба цахим шуудангийн хаягтай уялдуулснаар тухайн хэрэглэгчийг бэлэн бусаар төлбөр тооцоо хийсэн тухай бүр таньж, НӨАТУС-д автоматаар бүртгэх санал болгож буй шийдлийг хэрэгжүүлэхэд татварын алба, арилжааны банкууд технологийн хувьд хүндрэлгүй, шийдэх бүрэн боломжтой хэмээн үзэж байна.

Ном зүй:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, <http://legalinfo.mn/law/details/11227>
2. Цахим төлбөрийн баримтын систем <http://www.ebarimt.mn/>
3. MNS 6529 Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримт. Ерөнхий шаардлага, МУ-ын стандарт, 2015 он
4. Хөдөлгөөнт банкны тайлан, 2017 оны 3 дугаар сар, Монгол Банк, <https://www.mongolbank.mn/documents/paymentsystems/2017Q3HB.pdf>
5. Төлбөрийн системийн тайлан, 2017 оны 3 дугаар сар, Монгол Банк, https://www.mongolbank.mn/documents/paymentsystems/201703_report_paymentsystems.pdf
6. Татварын ерөнхий хууль, <http://www.legalinfo.mn/law/details/473?lawid=473>
7. НӨАТУС-ийн статистик, 2016-2017, ГТСМТ УУГ

Easy Solution for Automatic Registration of End Users' e-Receipt to VAT Promotion System

Uyanga S.* and Binderya B.

Department of Information and Computer Science, School of Engineering and Applied Sciences,
National University of Mongolia, Ikh surguuliin gudamj-3, Ulaanbaatar-14201

*uyanga@seas.num.edu.mn

Received on 04.02.2018; revised on 09.06.2018; accepted on 09.20.2018

Abstract

According to VAT law, there are two promotions that individuals can enjoy, taxpayer have refund of up to 20% of tax paid that tax year from transactions made with tax withholder and participate in the lottery. Since the implementation of the law 31.5 billion tugrug was refunded to 497,465 individuals in the year of 2017 and 78.1 billion tugrug to 654,168 individuals in the year of 2018. Even though individuals actively register receipts, approximately 40% of all printed receipts are left unregistered. This is happening due to noncompliance of taxpayers operating at large markets, trade centers, sums and villages, as well as due to technological shortages and nonprinting of receipts. So there is need for solution to issue and register e-receipts without causing complication to taxpayers and end users. In this article we have addressed the easy solution for automatic registration of end users' e-receipts to VAT Promotion system.

Key words: Tax system, taxpayer, VAT Promotion system, payment receipt, ebarimt, non-cash payment

Цэгэн гэрэл үүсгэгч дэлгэцийн нягтшилыг сайжруулах арга

Д.Номин-Эрдэнэ, Б.Ганбат*

Монгол Улсын Их Сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим

*ganbat@seas.num.edu.mn

Хүлээн авсан: 2018.03.30, засварласан: 2018.09.06, зөвшөөрсөн: 2018.09.15

Хураангуй

Тусгай зориулалтын нүдний шилгүйгээр гурван хэмжээст (3D)-ээр үздэг нийлмэл дүрсэн дэлгэцийн нэг төрөл болох Цэгэн гэрэл үүсгэгч буюу Point Light Source (PLS) дэлгэцийг энгийн хэрэглээнд нэвтрүүлэхэд нэг цэгийн хэмжээ том буюу нягтшил бага, харагдах өнцөг бага зэрэг дутагдалтай. Энэхүү судалгааны ажлаар уламжлалт PLS дэлгэцийн нягтшилыг 3 дахин сайжруулсан шинэ аргыг танилцуулна. Нягтшилыг сайжруулахдаа уламжлалт PLS дэлгэц дээр нэмэлт гэрэл үүсгэгч ашигласан. Туршилтын үр дүнгээс харахад линз матрицын нэг элементар линзийн ард есөн цэгэн гэрэл (хэвтээ 3, босоо 3) үүсэж байгаа бөгөөд цэгэн гэрэл үүсгэгчдийн хоорондох зай 3 дахин багассан учраас уламжлалт PLS дэлгэцийн нягтшилыг 3 дахин сайжруулсан.

Түлхүүр үг: Integral Imaging Display, Point Light Source Display

1. Удиртгал


Гурван хэмжээст (3D) дэлгэцийн технологиуд олон төрөл байдаг [1-4]. Үүнээс нийлмэл дүрсэн [1, 4] дэлгэцийн нэг төрөл PLS дэлгэцийн үүсгэсэн бодит 3D дүрсийг үзэгч тусгай шилгүйгээр, өнгөт, хэвтээ болон босоо тэнхлэгийн дагуу 3D-ээр, үзэгчийн байрлалаас үл хамаарч хардаг гэх мэт олон давуу талтай. Үүнээс PLS дэлгэц нь нийлмэл дүрсэн дэлгэцээс гүний хязгаарлалтгүй, хоёр хэмжээст (2D) болон 3D горимд ажилдгаараа онцлогтой. Хэдий тийм боловч харагдах өнцөг бага [5-10], нягтшил бага зэрэг дутагдалтай [11-14]. PLS дэлгэцийн нягтшил нь хөрш цэгэн гэрэл үүсгэгчийн хоорондын зайгаар тодорхойлогддог. Уг дэлгэцийн үүсгэсэн бодит 3D дүрс нь нягтшил бага буюу цэгэн гэрэл үүсгэгчийн хоорондын зай их байгаа нь чанар муутай харагдаж энгийн хэрэглээнд нэвтэрч чадахгүй байна. Yongri Piao нар толь ашиглан нягтшилыг сайжруулсан боловч толь нь хийсвэр линз матриц үүсгэж байгаа мэтээр тооцоолсон элементар зураг нь хоорондоо давхардах, элементар зургийг удаан үүсгэх зэрэг дутагдалтай [15]. Yunhee Kim нар Pinhole массивыг (олон жижиг нүхтэй хаалт) X, Y тэнхлэг дагуу цахилгаанаар хөдөлгөн нягтшилыг 3 дахин сайжруулсан боловч байнга механик хөдөлгөөн хийдэг, байрлал бүрд элементар зургийг өөрчилдөг дутагдалтай [16]. Jae-Hyeung Park нар PLS дэлгэцийн цуглуулагч линз болон

линз матриц хоёрын хооронд линз матриц нэмж байрлуулан дэлгэцийн нягтшилыг сайжруулсан боловч линз матриц нэмэх тусам өртөг өндөртэй, зузаан дэлгэц болдог сул талтай [17]. Энэхүү өгүүлэлд 3 Ч 3 гэрэл үүсгэгч нэмж байрлуулснаар PLS дэлгэцийн цэгэн гэрэл үүсгэгчийн хоорондын зайг 3 дахин багасгаж, нягтшилыг 3 дахин сайжруулсан шинэ аргын туршилтын үр дүнг танилцуулна.

2. PLS дэлгэцийн нягтшил

Нийлмэл 3-D дүрсэн дэлгэцийн нэг төрөл болох PLS дэлгэцийн бүтцийг хажуугаас нь дүрслэн Зураг 1-д үзүүлэв. PLS дэлгэц нь гэрэл үүсгэгч, цуглуулагч линз, линз матриц, Spatial Light Modulator (SLM) дэлгэцээс бүрдэнэ. Линз матриц нь жижиг элементар линзүүдээс бүрдэнэ. Цуглуулагч линзийн фокусын f_1 зайд, оптик гол тэнхлэг дагуу гэрэл үүсгэгчийг байрлуулна. Гэрэл үүсгэгчээс цацарсан гэрэл цуглуулагч линзээр нэвтрэхдээ параллель цацрагууд болоод линз матрицын элементар линз бүрийн урд фокусын f зайд цугларч олон гэрэл үүсгэгч байгаа мэт харагдана. Үүнийг цэгэн гэрэл үүсгэгч гэж нэрлэнэ. Цэгэн гэрэл үүсгэгч бүрээс цацарсан цацрагууд линз матрицын элементар линз бүрийн PL хэмжээтэй талбайд хоорондоо үл давхцах ба $2 \cdot f$ зайд SLM дэлгэцийг байрлуулна.

Зураг 1-д үзүүлснээр PLS дэлгэцийн урд байх Z, Y тэнхлэгийн дагуу z_1 , y_1 зайд байрлах I_1 нийлмэл цэгийг (3D цэг) линз матрицын элементар L_2-L_7 линзүүдийн үүсгэж байгаа цэгэн гэрэл P_2-P_7 үүсгэгчээс цацарсан цацрагууд SLM дэлгэцээр модуляцлагдан Elemental Image (EI) $EI_{2,1}-EI_{7,1}$ -ийн хөндлөн огтлолцлоор үүсгэнэ.



Зураг 1. PLS дэлгэцийн ажиллах зарчим.

Мөн PLS дэлгэцийн урд байх Z, Y тэнхлэгийн дагуу z_2 , y_2 зайд байрлах I_2 нийлмэл цэгийг линз матрицын элементар L_8-L_{11} линзүүдийн үүсгэж байгаа цэгэн гэрэл P_8-P_{11} үүсгэгчээс цацарсан цацрагууд SLM дэлгэцээр модуляцлагдан $EI_{8,2}-EI_{11,2}$ -ийн хөндлөн огтлолцлоор үүсгэнэ. Цэгэн гэрэл P_{12} үүсгэгчээс гарсан цацрагууд нийлмэл цэг I_2 дээр ирэхгүй. Зураг 1-д үзүүлснээр AB цэгийн хоорондын зай нь L_{12} элементар линзийн хэмжээтэй тэнцүү учраас цэгэн гэрэл P_{12} үүсгэгчээс тархах цацрагуудын SLM дээр туссан хэмжээнээс хэтэрсэн байна. Өөрөөр хэлбэл цэгэн гэрэл P_{12} үүсгэгчээс тарах гэрлийн мужаас гадна байна. Уг цацрагийг тасархай зураасаар Зураг 1-д үзүүлэв. PLS дэлгэцийн нягтшил (R)-ыг өмнөх ажлуудад [11-14] линз матрицын нэг жижиг элементар линзийн хэмжээний (тэгш өнцөгт) урвуугаар тодорхойлсон байдаг.

$$R = \left(\frac{1}{P_L}\right) \quad (1)$$

Үүнд: P_L нь линз матрицын нэг жижиг линзийн хэмжээ бөгөөд мм-ээр хэмжигдэнэ. Томъёо (1)-ээс

линз матрицын элементар линзийн хэмжээ бага байх тусам PLS дэлгэцийн нягтшил сайжирна.


Жишээ нь: Томъёо (1)-ээр PLS дэлгэцийн цэгэн гэрэл үүсгэгч бүрийн хоорондын зайтай тэнцүү линз матрицын элементар линзийн хэмжээ 5 мм гэвэл нягтшил нь урвуугаар тодорхойлогдож $1/5=0.2$ болно. Энгийн хоёр хэмжээст LCD дэлгэцийн нэг цэгийн хэмжээ нь дунджаар 0.25 мм гэвэл нягтшил нь $1/0.25=4$ болно. Үүнээс PLS дэлгэцийн нягтшил нь энгийн хэрэглээнд маш бага байна. PLS дэлгэцийн нягтшил бага байдаг учраас нягтшилыг сайжруулах өөрсдийн шинэ аргыг санал болгож байна.

3. Нягтшилыг сайжруулах арга

Зураг 2-д бидний дэвшүүлж буй шинэ аргыг хажуугаас нь дүрслэн үзүүлэв. Уг PLS дэлгэц нь нэмэлт гэрэл үүсгэгч LS_1-LS_3 , цуглуулагч линз, линз матриц, SLM дэлгэцээр бүрдэнэ. 3×3 ширхэг нэмэлт гэрэл үүсгэгчийг цуглуулагч линзийн ард (2)-р томъёогоор тодорхойлогдсон S зайгаар байрлуулна.

$$S = \left(\frac{P_L f_1}{n}\right) \quad (2)$$

Үүнд: f_1 нь цуглуулагч линзийн фокусын зай (мм), f нь линз матрицын фокусын зай (мм), n нь хэвтээ болон босоо тэнхлэг дагуух нэмэлт гэрэл үүсгэгчийн тоо.



Зураг 2. PLS дэлгэцийн нягтшилыг сайжруулах арга.

Жишээ нь: Зураг 2-д үзүүлснээр нэмэлт гэрэл үүсгэгч LS_1 - LS_3 -ээс гарсан гэрлийн цацраг цуглуулагч линзээр нэвтрэн оптик гол тэнхлэгтэй параллель чиглэлтэй болж линз матрицын элементар линз бүрээр нэвтэрч түүний урд талд, фокусын f зайд цугларч есөн (хэвтээ 3, босоо 3) цэгэн гэрэл үүсгэгчийг үүсгэнэ.

Эдгээр цугларсан цэгэн гэрэл үүсгэгчийн тоо нь Зураг 1-д үзүүлсэн уламжлалт PLS дэлгэцийн цэгэн гэрэл үүсгэгчийн тооноос 3 дахин их болж, шинэ аргын цэгэн гэрэл үүсгэгчийн хоорондын зай 3 дахин багасна. Шинэ аргаар PLS дэлгэцийн нягтшилыг дараах томъёогоор илэрхийлнэ.

$$R = \left(\frac{3}{P_L}\right) \quad (3)$$

(1), (3) томъёонуудаас харахад уламжлалт PLS дэлгэцийн нягтшил 3 дахин сайжирна. Зураг 2-д үзүүлснээр линз матрицын урд талд, цэгэн гэрэл үүсгэгчээс тархах цацрагууд хоорондоо давхцахгүй зай болох фокусын зайнаас 5 дахин бага $f/5$ зайд SLM дэлгэцийг байрлуулна. Зураг 1-д үзүүлсэн нийлмэл I_2 цэг нь 4 ширхэг цэгэн гэрэл үүсгэгчээс цацарсан цацрагууд SLM дэлгэцээр модуляцлагдан 4 ширхэг EI-ийн хөндлөн огтлолцоор үүсэж байсан бол X, Z тэнхлэг дагуу ижил зайд байрлах Зураг 2-д үзүүлсэн нийлмэл I_2 цэг нь 10 ширхэг цэгэн гэрэл үүсгэгчийн 10 ширхэг EI-ийн хөндлөн огтлолцол дээр үүсэж байна.

4. Туршилт болон үр дүн


Туршилтад ашигласан элементүүдийн параметруудийг Хүснэгт 1-д үзүүлэв. Томъёо (2) ёсоор Хүснэгт 1-ийн үзүүлэлтийг ашиглан нэмэлт гэрэл үүсгэгч хоорондын зай нь $S=6.24$ мм болсон. Тиймээс гэрэл үүсгэгчээр Surface-Mount Device Light-Emitting Diode (SMD LED)-ийг ашиглав. SMD LED нь үнэ хямд, чадал бага зарцуулдаг, маш жижиг хэмжээтэй.

Хүснэгт 1. Туршилтын параметрууд

Зориулалт	Үзүүлэлт
SMD LED	1.25 мм (Б) Ч 2 мм (Х)
SMD LED-ийн тоо	3 (Б) Ч 3 (Х)
Цуглуулагч линзийн хэмжээ	50.8 мм (Б) Ч 50.8 мм (Х)
Цуглуулагч линзийн фокусын зай	61.8 мм
Линз матрицын элементар линзийн тоо	50 (Б) Ч 50 (Х)
Элементар линзийн хэмжээ	1 мм (Б) Ч 1 мм (Х)
Линз матрицын фокусын урт	3.3 мм
Линз матрицаас SLM дэлгэц хүртэлх зай	4.125 мм
SLM дэлгэцийн цэгийн тоо	768 (Б) Ч 1024 (Х)
SLM дэлгэцийн нэг цэгийн хэмжээ	0.036 мм
SLM дэлгэцийн хэмжээ	27.64 мм (Б) Ч 36.86 мм (Х)

^aБ – босоо, Х - хэвтээ


Нэмэлт гэрэл үүсгэгч нь хэвтээ болон босоо тэнхлэг дагуу 3 Ч 3 ширхэг байх ба нэмэлт гэрэл үүсгэгчийг Зураг 3-д үзүүлснээр голын гэрэл үүсгэгч LS_5 нь дангаараа асах эсвэл LS_1 - LS_9 нэмэлт гэрэл үүсгэгч бүгд асах унтраалгатай хавтан дээр гагнасан. Голын гэрэл үүсгэгч LS_5 нь дангаараа асах тохиолдолд уламжлалт PLS дэлгэцийн нөхцөл биелнэ. Нэмэлт гэрэл үүсгэгч LS_1 - LS_9 бүгд асах тохиолдолд бидний дэвшүүлж буй шинэ аргын PLS дэлгэцийн нөхцөл биелэх юм.



Зураг 3. PLS дэлгэцийн нягтшилыг сайжруулсан аргын геометр байгуулалт.

Бидний дэвшүүлж буй шинэ аргын туршилтын геометр байгуулалтыг Зураг 3-д үзүүлэв. PLS дэлгэц нь хоорондоо 10 мм, SLM дэлгэцээс 10 мм болон 20 мм зайд байрлах 'O', 'I' нийлмэл дүрсийн үүсгэж байхаар туршилт хийсэн. Туршилтаа X, Z, Y=0 буюу хэвтээ тэнхлэг дагуу хийсэн. PLS дэлгэц нь Y, Z, X=0 буюу босоо тэнхлэг дагуу туршсан үр дүн нь хэвтээ тэнхлэг дагуух үр дүнтэй ижил юм.


Туршилт хийхээс өмнө PLS дэлгэц нь Зураг 3-д үзүүлсэн геометр байгуулалтын дагуу хоорондоо 10 мм SLM дэлгэцээс 10 мм, 20 мм зайд байрлах 'O', 'I' нийлмэл дүрсийг үзүүлж байхаар EI-ийг үүсгэх шаардлагатай.



Зураг 4. Үүссэн EI (a) уламжлалт арга, (б) шинэ арга


Уламжлалт PLS дэлгэцийн EI-ийг үүсгэхдээ нэг EI-ийн хэмжээ элементар линзийн хэмжээ P_L -тэй тэнцүү байна гэж үздэг. Өөрөөр хэлбэл EI-ийн цэг нь тухайн цэгэн гэрэл үүсгэгчээс цацарсан гэрлийн мужид байна гэсэн үг. Уг нөхцөлийн дагуу 'O' болон 'I'-ийг дэлгэцийн урд өөр өөр зайд байна гээд Matlab дээр үүсгэсэн EI-ийг Зураг 4(a)-д үзүүлэв.

Нэмэлт гэрэл үүсгэгчтэй нягтшилыг сайжруулсан PLS дэлгэцийн EI-үүд хоорондоо давхцахгүй байх ёстой гэдгээс EI-ийн хэмжээ нь $P_L/5$ -тай тэнцүү байна. EI цэг нь тухайн цэгэн гэрэл үүсгэгчээс цацарсан гэрлийн мужид байна гэсэн нөхцөлийн дагуу шинэ PLS дэлгэцийн EI-ийг үүсгэснийг Зураг 4(б)-д үзүүлэв. Шинэ аргад линз матрицын нэг элементар линз бүр есөн (3 хэвтээ, 3 босоо) цэгэн гэрэл үүсгэнэ. Ийм учраас EI-ийн хэмжээ багасна. Энэ нөхцөлийн дагуу үүсгэхээр SLM-ийн зарим хэсэг нь EI-гүй буюу үргэлж хар байна. Энэ хэмжээ нь нэг элементар линзийн хэмжээний $2 \cdot P_L/5$ байна. Өөрөөр хэлбэл шинэ арга нь P_L хэмжээтэй элементар линз бүр $2 \cdot P_L/5$ хэсгийг ашиглахгүй гэсэн үг. Үүнээс болоод Зураг 4(б)-д үзүүлсэн нягтшилыг сайжруулах шинэ аргын EI нь Зураг 4(а)-д үзүүлсэн уламжлалт PLS дэлгэцийн EI-ээс бүдэг харагдаж байна.




Зураг 5. Лабораторийн орчинд угсарсан PLS дэлгэц.

Зураг 5-д үзүүлснээр лабораторийн орчинд PLS дэлгэцийг угсарч линз матрицын фокусын f зайд камерын фокусыг тохируулж, PLS дэлгэцийн үүсгэж байгаа цэгэн гэрлийн туршилт хийсэн. Зураг 6(а)-д гэрэл үүсгэгч LS_5 -ыг асаасан буюу уламжлалт PLS дэлгэц нь цэгэн гэрэл үүсгэж байгааг, Зураг 6(б)-д нэмэлт гэрэл үүсгэгч LS_1 - LS_9 -ийг асаасан буюу нягтшилыг 3 дахин сайжруулсан шинэ аргын PLS дэлгэц нь цэгэн гэрэл үүсгэж байгаа туршилтын үр дүнг үзүүлсэн байна. Туршилтад $P_L = 1$ мм линз матриц ашигласан учраас Зураг 6(а)-д цэгэн гэрэл үүсгэгч хоорондох зай 1 мм байна. Шинэ аргаар үүсгэсэн цэгэн гэрэл хоорондох зай 0.33 мм байна. Туршилтын үр дүнгээс харахад цэгэн гэрэл үүсгэгчийн хоорондын зай 3 дахин багассан байна.




Зураг 6. Цэгэн гэрэл үүсгэж байгаа (а) уламжлалт PLS дэлгэц болон (б) шинэ аргын PLS дэлгэц

Уламжлалт PLS дэлгэцийг туршихдаа Зураг 5-ын гэрэл үүсгэгч LS_5 асааж, линз матрицын фокусыг 2 дахин авсан зайд SLM дэлгэцийг байрлуулж Зураг 4(а)-д үзүүлсэн EI-ийг SLM дэлгэцэд гаргасан. Үүний туршилтын үр дүнг Зураг 7(а)-д үзүүлсэн байна.



Зураг 7. Туршилтын үр дүн (а) уламжлалт PLS дэлгэц, (б) нягтшилыг сайжруулсан PLS дэлгэц

Нягтшилыг 3 дахин сайжруулах PLS дэлгэцийг туршихдаа Зураг 5-ийн нэмэлт гэрэл үүсгэгч LS_1 - LS_9 -ийг асааж линз матрицын фокусын зай дээр фокусын зайг 5 дахин бага зайг нэмсэн $f+f/5$ зайд SLM дэлгэцийг байрлуулж Зураг 4(б)-д үзүүлсэн EI-ийг SLM дэлгэцэд гаргасан. Нягтшилыг 3 дахин сайжруулах аргын туршилтын үр дүнг Зураг 7(б)-д үзүүлсэн байна. Зураг 7-д үзүүлснээр PLS дэлгэцийн нягтшил 3 дахин ихсэж байгаа нь харагдаж байна.



Зураг 8. Туршилтын үр дүн (а) уламжлалт PLS дэлгэц, (б) дэвшиүүлж буй PLS дэлгэц.

Зураг 8-аас уламжлалт болон шинэ арга перспектив ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл баруун талаас харахад 'O', 'I' нийлмэл дүрсийн хоорондох зай ойртсон. Зүүн талаас харахад хоорондох зай холдсон байна. Тиймээс шинэ PLS дэлгэц нь 3-D дүрсийг амжилттай үүсгэж байна гэж дүгнэж болно. Зураг 8(а)-ын уламжлалт PLS дэлгэцийн үүсгэсэн нийлмэл дүрсийн цэг хоорондын зай нь нүдээр харахад мэдэгдэж байгаа бөгөөд хол зайтай хэдэн цэг буюу чанар муутай харагдаж байна. Зураг 8(б)-д шинэ дэлгэцийн үр дүнг үзүүлсэн бөгөөд уламжлалт аргын үр дүнтэй харьцуулбал цэгэн гэрэл хоорондох зай бараг

ажиглагдахгүй байна. Өөрөөр хэлбэл Зураг 8(а)-ын уламжлалт PLS дэлгэцийн үүсгэсэн нийлмэл дүрсийн нягтшилыг бодвол Зураг 8(б)-д шинэ аргын PLS дэлгэцийн нягтшил нь тасралтгүй үүсэж байгаа харагдаж байна. Бидний дэвшүүлж буй аргаар PLS дэлгэцийн нягтшил 3 дахин сайжирсан ба линз матрицын элементар линзийн хэмжээ 1 мм гээд PLS дэлгэцийн нягтшил нь 3 болж байна.

5. Дүгнэлт

Бидний дэвшүүлж буй аргад нэмэлт гэрэл үүсгэгчийг цуглуулагч линзийн ард Томъёо (2) зайтайгаар байрлуулснаар түүний цацрагууд нь линз матрицын элементар линз бүрийн урд цугларч гурван цэгэн гэрэл үүсгэж байгаа бөгөөд уламжлалт PLS дэлгэцийн цэгэн гэрэл хоорондын зайг 3 дахин багасгасан. Туршилтын үр дүнгээс харвал шинэ аргаар PLS дэлгэцийн цэгэн гэрэл үүсгэгч хоорондын зайг 3 дахин бага байгаагаас нягтшил 3 дахин ихсэж байна. PLS дэлгэцийн нягтшилыг сайжруулснаар үзэгч 3-D дүрсийг чанартайгаар харах боломжтой болсон.

Зохиогчийн оролцоо

Д.Номин-Эрдэнэ тооцоо хийж EI үүсгэж, туршилтууд хийсэн. Б.Ганбат туршилтад гарсан алдааг засаж сайжруулан өгүүлэл бичсэн.

Ном зүй:

1. Poon, T.-C (2006) *Digital Holography and Three-Dimensional Display*, Springer, New York.
2. Halle, M.M. et al. (1997) *Computer Graphic: Autostereoscopic displays and computer graphics*, 2nd edn. ACM Siggraph, Vol. 31, pp. 58–62.
3. Knut, L. et al. (1998) *Proc: New portable FELIX 3D display*, SPIE 3296, pp. 204.
4. Lippmann, G. (1908) *Comptes-Rendus Academie des Sciences: La Photographie Integrale*, vol. 146, pp. 446.
5. Park, J.-H. et al. (2005) Viewing Angle Enhancement of Three-Dimension/TwoDimension Convertible Integral Imaging Display Using Double Collimated or Noncollimated Illumination. *Jpn. J. Appl. Phys*, vol. 44, pp. 991–994.
6. Park, J.-H. et al. (2001) Analysis of viewing parameters for two display methods based on integral photography. *Appl. Opt*, vol. 40, pp. 5217–5232.
7. Min, S.-W. et al. (2003) Enhanced three-dimensional integral imaging system by use of double display devices. *Appl. Opt*, vol. 42, pp. 4186–4195.
8. Choi, H. et al. (2005) Wide-viewing-angle 3D/2D convertible display system using two display devices and a lens array. *Opt. Express*, vol. 13, pp. 8424–8432.
9. Park, J.-H. et al. (2004) Depth-enhanced three-dimensional–two-dimensional convertible display based on modified integral imaging. *Opt. Lett*, vol. 29, pp. 2734–2736.
10. Choi, H. et al. (2006) A thin 3D-2D convertible integral imaging system using a pinhole array on a polarizer. *Opt. Express*, vol. 14, pp. 5183–5190.
11. Alam, A. et al. (2012) Resolution Enhancement of Integral Imaging Three-Dimensional Display Using Multi-Directional Elemental Images. *Journal of the Society for Information Display*, vol. 20(4), pp. 175–243.
12. Choi, H. et al. (2003) Multipleviewing-zone integral imaging using a dynamic barrier array for threedimensional displays. *Appl. Opt*, vol. 11, pp. 927–932.
13. Shin, D. et al. (2008) Resolution-enhanced three-dimensional image reconstruction by use of smart pixel mapping in computational integral imaging. *Appl. Opt*, vol. 47, pp. 6656–6665.
14. Hahn, J. et al. (2009) Uniform angular resolution integral imaging display with boundary folding mirrors. *Appl. Opt*, vol. 48, pp. 504–511.
15. Piao, Y. et al. (2016) Resolution Enhanced Computational Integral Imaging Re-construction by Using Boundary Folding Mirrors. *Optical Society of Korea*, vol. 20, pp. 363–367.
16. Kim, Y. et al. (2007) Point light source integral imaging with improved resolution and viewing angle by the use of electrically movable pinhole array. *Opt. Express*, vol. 15, pp. 18253–18267.
17. Park, J. et al. (2005) Resolution-enhanced three-dimension / two-dimension convertible display based on integral imaging. *Opt. Express*, vol. 13, pp. 1875–1884.

Resolution-Enhanced Point Light Source Display

Nomin-Erdene Dalkhaa and Ganbat Baasantseren*

Department of Electronics and Communication Engineering, School of Engineering and Applied Sciences,
National University of Mongolia

*ganbat@seas.num.edu.mn

Received on 03.20.2018; revised on 09.06.2018; accepted on 09.15.2018

Abstract

The Point Light Source (PLS) display is one kind of Integral Imaging that is the three-dimensional (3D) display. Limitations of the PLS display include those regarding the viewing angle and the resolution. A PLS display with the high resolution is proposed. We used the light source array (3 x 3) to increase the resolution of the PLS in the horizontal and vertical directions. From the experimental results, the proposed method enhances three times higher than conventional PLS display.

Key words: Integral Imaging Display, Point Light Source Display

Characteristics and Concentration of White Dust and The Particulate Matter (PM₁₀) in Erdenet city, Mongolia

Lkhagvajargal B.¹, Batdelger B.^{1,2}, Sonomdagva Ch.^{1*}, Bayarbat B.¹,
Atsushi Matsuki²

¹ Department of Environment and Forest Engineering, School of Engineering and Applied Sciences, National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

² Institute of Nature and Environmental Technology, Kanazawa University, Kanazawa, Ishikawa 920-1192, Japan

*ch_sonomdagva@num.edu.mn

Received on 04.12.2018; revised on 07.06.2018; accepted on 09.15.2018

Abstract

The purpose of this research was to determine characteristics and composition of white dust in the tailings pond of Erdenet Copper Mining (ECM) and to identify mass concentration of the particulate matter (PM₁₀) around Erdenet city. Based on these goals, we determined critical level of flaring speed for white dust and how to reduce this speed. Meteorological data and particulate matter (PM₁₀) were collected from the Research Institute of Meteorology, Hydrology and Environment (IRIMHE) and Air Quality Monitoring Station (AQMS) in Erdenet city. The mass concentration of particulate matter (PM₁₀) were analyzed and compared with WHO guidelines and Mongolian air quality standard (MNS4585:2016). Critical speed of flaring was tested in the laboratory condition and based on that we had estimated total number of days that white dust released into the air. In addition, in order to reduce flaring white dust, watering method was tested in the laboratory and based on that the moisture amount to avoid flaring of white dusts had estimated. Results were shown that spring and autumn have a significantly higher level of mass concentration of PM₁₀ in Erdenet city. It was caused by the stagnant atmosphere which leads to pollution's cumulative effect and white dust from the storage of tailings pond during spring and autumn. Particle size of white dust had two types, 2-0.05 mm sandy and 0.05-0.002 mm dusty; yet it had a high concentration of As, Pb, Zn and Cu that were higher than the Mongolian national standard of heavy metals for soil. The critical level of flaring speed was about 4-5 m/s. Based on this critical level of flaring speed for white dust, on average 25 days per month had flaring white dust. The test result in the laboratory was shown that 5 percent of moisture would reduce the flaring of white dust. Therefore, it is possible to use wastewater reserve for watering to reduce white dust flaring.

Key words: PM₁₀, white dust, characteristics, heavy metal, tailings pond

1. Introduction

Erdenet is definitely one of the most polluted cities and it might be the second polluted city in Mongolia in terms of annual mass concentration of particulate matter (PM₁₀). The population is increasing and due to manufacturing and its' pollution of city air quality has been above the standard limit for the last years (METM, 2015). One of the main pollution source of heavy metals and trace elements within the Erdenet Mining Corporation environment is the white dust from the storage of tailings pond. Erdenet Mining Corporation is one of the biggest ore mining and ore processing factory in Asia. The main mineral deposit, extracted by the Corporation was the Erdenetiin-Ovoo area which locates 400 kilometers

northwest from Ulaanbaatar city, 180 kilometers east from Dar-khan city, 60 kilometers northern from the center of Bulgan aimag (Ziadat et al., 2015). In 2006, there are 500 million tons' sands, 25 million m³ wastewater accumulated in tailings pond (Khukhuu et al., 2008). Moreover, white dust and heavy metals in it in ECM tailings are becoming problem for population of around Erdenet city in recent decades. Many researcher was studied the about it. For example; the result obtained from this research indicated that the area surrounding the copper mine in Erdenet, Mongolia is polluted with heavy metals especially with copper. This is attributed to the dust emission from mining activities in addition to vehicle emission in the area. This reflects the fact that mining activities

had a direct impact on atmospheric pollution with heavy metals in Erdenet, Mongolia (Baljinnyam et al., 2009). The general and mi-cro mode of country wind, humidity and, cold and warm air of the area effects for dissipation and disperse of white dust of tailings pond. The white dust distribution depends from the wind mode (Khukhuu et al., 2008). The white dust resulted from the mining process of Erdenet Mining Corporation is a fine dust, moves around when the wind speed is 5.4 m/sec or more landing on soil. Households, animals, plant near the industrial area is faced with the risk of being exposed to heavy metal and negative effect upon their health in the long run has been proven (Khukhuu et al., 2008; Bayalag, 2012).

In May and October, white dust dispersion would increase up to 38-68 km also these months are the

most spread months among all other months. During this time, mass concentration of PM_{10} was measured the highest in the air. Thereby, it's possible that white dust is the source of PM_{10} . White dust dispersion is related to precipitation, relative humidity and wind speed. From the analysis between rainy day and normal day, white dust distribution was four times lower when the rainy day. Therefore, precipitation is an important indicator that white dust spread (Lkhagvajargal et al., 2018).

2. (Materials &) Methods

2.1. Study area, materials and field study

Erdenet city, the second largest industrial city, is located in Western Mongolia at an elevation of 1580 meters above sea level character-ized by high annual sunshine exposure, short dry summer months and




Fig. 1. Study area with sampling locations; (a) Erdenet city in Mongolia, (b) Erdenet mining area, (c) Sampling location of tailings pond area in Erdenet Copper Mining

long cold winter season climatic conditions (Badarch, 1971). Erdenet copper molybdenum mine and tailings pond is located northeast of Erdenet city (Fig. 1).

The mine area is a semiarid region with a typical continental climate of a short summer, long winter, and a vast temperature fluctuation. The coldest season is in January with a mean temperature of -22.2°C , while the warmest season in July has a mean temperature of 16.5°C . The dominant wind direction is from

the west and northwest, and the velocity reaches 20 m/s in spring. The maximum annual precipitation in the area is 355 mm, with 90 % falling between May and September. Average snow cover ranges from 5 to 8 cm (Tsegmid, 1969; Jambaaajamts, 2009).

The study was conducted a field study, a laboratory analysis, testing, experiments and statistical processing. Changes of the tailings pond area between 1985 and 2014 were used by measurement

data of ECM and tailings pond area of 2017 was calculated on satellite image. Meteorological data including precipitation, wind velocity, wind direction, air humidity and temperature was collected from a weather station in Erdenet, which is attached to the IRIMHE. The data of particulate matter (PM₁₀) was collected from AQMS in the Erdenet city (Tab. 1).

Tab. 1. The data used in the survey

№	Name of data, unit	Year	Time duration
1	Average wind velocity, m/s	2014-2015	Monthly average
2	Max wind velocity, m/s	2012-2015	Daily average
